

**АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ
ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН ТАЛААРХ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2026 оны 06 дугаар
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2026 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар явуулж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу явуулж, хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцлээ.

Монгол Улсын Их Хурлын даргын 2026 оны 248 дугаар захирамжаар Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн татварын харилцааг зохицуулсан хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуягаар ахлуулан 15 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Б.Заяабал 0-6 тэрбум, 6-10 тэрбум, 10 тэрбум төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжүүдийн тоо, төсөвт төвлөрүүлэх орлогын дүн болон жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд чиглэсэн татварын хөнгөлөлтийн талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг борлуулалтын орлогоос үл хамааран дэвшилтэд техник, технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг бууруулж, улмаар эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх боломжтой эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед ажлын хэсгээс сервер, өгөгдөл хадгалах болон боловсруулах зориулалтын тоног төхөөрөмж, график, тусгай зориулалтын процессор бүхий тооцоолон бодох төхөөрөмжийн элэгдэл тооцох хугацааг 3 жил болгож өөрчлөх зэрэг зарчмын зөрүүтэй 3 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Мөн хуулийн төсөлтэй холбогдуулан тухайн жилийн орлогод шатлалтайгаар албан татвар ногдуулах зэрэг зарчмын зөрүүтэй 4 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Н.НАРАНБААТАР